| | 18 | Үзэм: Өнгө :Хүрэн, бор, шаргал Амт:Чихэрлэг гадны нөлөөний гаж буруу амтгүй Чанар:Эрүүл ахуйн шаардлага хангасан, шороо чулуугүй байх Хэлбэр дүрс: Нэр төрөлдөө тохирсон хэлбэртэй байх Битүүмжлэл: Чанарын шаардлага хангасан сав баглаа боодолтой байх Хадгалах хугацаа: Үйлдвэрлэсэн он дуусах хугацаа тодорхой байх MNS CAC67:1999 стандарттай байна. | кг | 16000 | 50 | 800.000 |
| | 19 | Коровка печень : Нэр төрөлдөө тохирсон янз борийн дүрс бүхий хэлбэр хэмжээтэй байна. Хэлбэр хэмжээ нь тухайн нэр төрөлд жигд байна. Нэр төрөлдөө тохирсон жигд цайвар шаргал шаргалаас бор шаргал өнгөтэй ул тал нь харьцангуй бараан түлэнхийгүй байна. Зарим нэр төрөл нь түүхий эд өнгө оруулагч нэгдлээс хамаарч төрөл бүрийн өнгөтэй байж болно. Нэр төрөлдөө тохирсон өвөрмөц сайхан үнэртэй гадны үнэргүй байх, нэр төрөлдөө тохирсон чихэрлэг тосорхог буюу зарим түүхий эдийн өвөрмөц амтыг агуулсан байна. Дутуу зуурагдсан шинж тэмдэггүй бөөн гурилгүй гүйцэт болцтой | ш | 2750 | 500 | 1.375.000 |

| | | | | | | |
|--|----|--|---|-------|-----|-----------|
| | | Техникийн үзүүлэлтэд тавигдах шаардлага: Өнгө үзэмж, амт чанар, эрүүл ахуйн шаардлага хангасан байх. Хүнсний бүтээгдэхүүний стандартад нийцсэн, тээвэрлэлт, хадгалалт хамгаалалт, сав баглаа боодолын стандарт шаардлагад нийцсэн байх. Үйлдвэрлэсэн огноо ашиглагдах хугацаа шаардлага хангасан, шаардлагатай бүх шинжилгээнд хамрагдсан байх. MNS0158:1985 стандарттай байна. | | | | |
| | 20 | Жимсний варень: Гадаад байдал: Цэвэр жимсний варень өнгө үнэр амтанд гадны өөрчлөлт ороогүй бохирдолгүй, савны таглаа сав ,бүрэн байдлыг хангасан. Эрүүл ахуй: Эрүүл ахуй хангасан хүний биед хор нөлөөгүй байх жимсний варень нь байгалийн жимсийг 100% , жимсний зөвлөн эд агуулсан байх өнгө үнэр амт оруулагч ороогүй байх. Стандартын шаардлагын дагуу дараах мэдээлийг агуулсан шошготой байна. Үйлдвэрлэсэн газрын нэр, хаяг, хадгалах хугацаа, он, сар байх MNS 462-77 стандартын шаардлага хангасан. | ш | 6500 | 25 | 162.500 |
| | 21 | Зөгийн бал: Шинжилгээгээр бичил биетний ерөнхий тоо 10 гр-с ихгүй эмгэг төрөгч нян салс үүсгэгч нян коли илрээгүй байх монголд үйлдвэрлэсэн байх | ш | 3550 | 50 | 177.500 |
| | 22 | Хадны компод: Шинжилгээгээр бичил биетний ерөнхий тоо 10 гр-с ихгүй эмгэг төрөгч нян салс үүсгэгч нян коли илрээгүй байх | ш | 6200 | 25 | 155.000 |
| | 23 | Олон жимстэй овьёс: MNS 0244-2009 стандартыг хангасан чанарын шаардлага хангасан .төмөрлөг 3мг/кг-аас ихгүй үнслэг 0.75%-иас ихгүй.цавуулаг 30.0%иас багагүй . Хүчиллэг 4.0 Н-иас ихгүй чийглэг 15.5% иас ихгүй байх | ш | 15600 | 100 | 1.560.000 |
| | 24 | Шөлний байцаа: MNS 0244-2009 стандартыг хангасан чанарын шаардлага хангасан .төмөрлөг 3мг/кг-аас ихгүй үнслэг 0.75%-иас ихгүй.цавуулаг 30.0%иас багагүй . Хүчиллэг 4.0 Н-иас ихгүй чийглэг 15.5% иас ихгүй байх | ш | 4700 | 50 | 235.000 |
| | 25 | Далай байцаа: MNS 0244-2009 стандартыг хангасан чанарын шаардлага хангасан .төмөрлөг 3мг/кг-аас ихгүй үнслэг 0.75%-иас ихгүй.цавуулаг 30.0%иас багагүй . Хүчиллэг 4.0 Н-иас ихгүй чийглэг 15.5% иас ихгүй байх | ш | 4000 | 50 | 2.000.000 |

Бараа нийлүүлэлтийн хуваарь

[Захиалагч доорх хүснэгтийн 1-6 хүртэлх баганыг, тендерт оролцогч 7 дугаар баганыг бөглөнө]

| № | Барааны нэр | Тоо хэмжээ | Хэмжих нэгж, тун | ТӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг | Бараа нийлүүлэх хугацаа | |
|-----|---------------------------|---------------------------------------|------------------------------|--|--|--|
| | | | | | Захиалагч бараа хүлээн авах хугацаа (эхлэх болон дуусах хугацаа) | Нийлүүлэгчийн санал болгох хугацаа (Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө) |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | [Барааны нэрийг бичих] | [Нэгжийн тоо ширхгийг бичих] | [Хэмжих нэгжийг бичих] | [Бараа хүргэх газрын нэр] | [Гэрээ байгуулснаас хойш нийлүүлэх хугацаа бич. Жишээ нь: 2023.03.01-ээс 2023.03.20] | [6 дугаар баганад заасан хугацаанд багтаан нийлүүлэхээр санал болгож буй хугацааг бичих] |
| 2 | | | | | | |
| 3 | | | | | | |
| ... | | | | | | |

IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ НЭМЭЛТ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Захиалагч тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг үлдээж бусад шалгуур үзүүлэлтийг хасна.

Энэ бүлэг нь ТШЗ-ны зүйл бөгөөд захиалагч ТӨХ-д тусгайлан зөвшөөрсөн бол тендерийн үнэлгээ хийхэд тендерийн маягтад тусгасан үнийн санаалаас гадна ТШЗ-ны 35.1.6-д заасан нэг буюу хэд хэдэн хүчин зүйлийг мөнгөөр илэрхийлэн, тендерийн үнийг хийсвэрээр нэмэгдүүлэх замаар тендерийн харьцуулах үнийг тодорхойлон үнэлгээ хийх зорилгоор ашиглана.

Захиалагч энэ хэсэгт зааснаас өөр бусад аливаа шалгуур үзүүлэлт, аргачлалыг үнэлгээнд харгалзахгүй.

1. *Бараа нийлүүлэлтийн хуваарь: “Ашиглана”*
2. *Тендерт санал болгосон барааны урсгал зардал, үйл ажиллагааны баталгаа болон үр ашигтай байдал: “Ашиглахгүй”*
3. *Тендерт санал болгосон барааны борлуулалтын дараах үйлчилгээг захиалагчийн заасан газар үзүүлэх боломж: “Ашиглахгүй”*
4. *Тендерийн дагуу санал болгож байгаа барааны гол эд анги, зайлшгүй шаардлагатай сэлбэг хэрэгсэл болон үйлчилгээний зардал: “Ашиглахгүй”*

V БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МЯГТУУД

| | | |
|---------|--|---|
| Маягт 1 | Тендер илгээх маягт | 1 |
| Маягт 2 | Барааны үнийн задаргаа..... | 2 |
| Маягт 3 | Тендерийн баталгаа (банкны) | 4 |
| Маягт 4 | Тендерийн баталгаа (Засгийн газрын бондын болон Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаас)..... | 6 |
| Маягт 5 | Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл | 8 |
| Маягт 6 | Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл | 8 |
| Маягт 7 | Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл..... | 9 |

Маягт 1 Тендер илгээх маягт

[огноо]

Замын-Үүд сумын 4 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч Н.Сүхтогоо танаа

Манай [тендерт оролцогчийн нэр] нь танай байгууллагаас зарласан [тендер шалгаруулалтын нэр, дугаар] тендер шалгаруулалтад [үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичигт заасан хуваарийн дагуу бараа нийлүүлэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “тендер” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендерийн баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Тендерт оролцогч, түүний түншлэлийн гишүүнтэй холбоотойгоор тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 17.1-д заасан нөхцөл байдал үсээгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт үнийн хөнгөлөлт “санал болгоно” эсхүл “санал болгохгүй” гэж бичих]. [Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих].
5. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш **30 хоног тендерийн хүчинтэй хугацаа**
6. Тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 6 дугаар зүйл, 13.4 болон 17.1-д заасныг зөрчсөн, эсхүл тендерт хуурамч баримт бичиг, мэдээллийг хүргүүлсэн бол уг тендерийг илт худал мэдээлэл бүхий тендер гэж тооцохыг хүлээн зөвшөөрч байна.
7. Тендерт санал болгосон бараа нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.
8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд, эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр, албан тушаал, гарын үсэг, байгууллагын тамга, тэмдэг]:

Хаяг:

Маягт 2 Барааны үнийн задаргаа

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 |
|-----|-------------|--------------------------------------|---------------|-------------------------|-------------|---|--|--|--|--|
| № | Барааны нэр | Гарал үүслийн улс ⁴ | Тоо хэмжээ | Хэмжи х нэгж, тун | Нэгж үнэ | Нэр төрөл бүрийн бүгд үнэ (4x6) | Барааг эцсийн цэгт хүргэхэд шаардагдах дотоодын тээвэрлэлт болон бусад үйлчилгээний үнэ | Бараа нийлүүлэхэд ногдох татвар, хураамж | Нэр төрөл бүрийн нийт үнэ (7+8+9) | Монгол Улсын гарал үүсэлтэй бараа мөн эсэх ⁵ |
| 1 | | | | | | | | | | Тийм/Үгүй |
| 2 | | | | | | | | | | |
| ... | | | | | | | | | | |
| | | | | | | | Тендерийн нийт үнэ | | | |

[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,
эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,
албан тушаал, гарын үсэг, байгууллагын
тамга, тэмдэг]:

Маягт 3 Тендерийн баталгаа (банкны)

Баталгаа хүлээн авагч: **[захиалагч байгууллагын нэр, хаягийг бичих]**

Огноо: **[баталгаа гаргасан огноог бичих]**

Дугаар: **[тендерийн баталгааны дугаар бичих]**

Баталгаа гаргагч: **[хэвлэмэл хуудсанд бичигдээгүй бол баталгаа гаргагч банкны нэр, хаягийг бичих]**

1. Баталгаа гаргагч нь **[тендерт оролцогчийн нэр]** (цаашид “тендерт оролцогч” гэх)-аас **[тендер шалгаруулалтын нэр, дугаар]** тендер шалгаруулалтад оролцож тендер (цаашид “тендер” гэх) хургуулэхтэй холбогдуулан баталгаа хүлээн авагчийн өмнө нийт **[мөнгөн дүн]**-ийн⁶ төлбөрийн үүрэг хүлээх баталгаа гаргаж байна.
2. Энэхүү баталгааны дагуу төлбөр төлөх үүрэг дор дурдсан нөхцөлд үүснэ. Үүнд:
 - 2.1. Тендер нээсний дараа, тендерийн хүчинтэй байх хугацаа (сунгасан хугацааг оролцуулан цаашид “Тендер хүчинтэй байх хугацаа” гэх) дуусахаас өмнө тендерт оролцогч тухайн тендерээс бүхэлд нь эсхүл хэсэгчлэн татгалзсаныг бичгээр мэдэгдсэн;
 - 2.2. Тендерт оролцогч гэрээ байгуулах эрх авсан үед тендерийн баримт бичигт заасны дагуу:
 - 2.2.1. ТШЗ-ны 41 дүгээр зүйлд заасны дагуу гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулаагүй;
 - 2.2.2. гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй;
 - 2.2.3. тендерийн үнийн алдааны залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй, эсхүл зөвшөөрсөн эсэх тухай хариуг бичгээр ирүүлээгүй.
 - 2.3. Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллага тендерт оролцогчийн гаргасан гомдлыг бүхэлд нь үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн.
3. Дээр тодорхойлсон аль нэг нөхцөл үүссэнийг дурдаж төлбөр төлүүлэх тухай захиалагчийн анхны шаардлагыг хүлээн авсан даруйд баталгаа гаргагч төлбөрийг тус мэдэгдэлд заасан Монгол Улсын Сангийн яамны дансанд шилжүүлнэ. Баталгаа гаргагчаас төлөх шаардлагын хэмжээ нь 1-д заасан мөнгөн дүнгээс хэтрэхгүй ба 2.3-т заасан нөхцөл үүссэн тохиолдолд 20 сая хүртэл төгрөг эсхүл түүнтэй тэнцэх гадаад валютаас хэтрэхгүй байна.
4. Энэхүү баталгаа Тендер хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байна. Баталгаа гаргагч энэ хугацаанаас өмнө гэрээ байгуулсан тухай мэдэгдлийг хүлээн авсан тохиолдолд баталгааг хугацаанаас өмнө хүчингүй болгож болно.
5. Энэхүү баталгааны дагуу гаргах аливаа шаардлагыг баталгааны хүчинтэй хугацаанд багтааж баталгаа гаргагчид мэдэгдэнэ.
6. Энэхүү баталгааг дээр дурдсанаас бусад үндэслэлээр хүчингүй болгосонтой холбоотой хариуцлагыг баталгаа гаргагч хүлээнэ.

[Баталгаа гаргагч нь гадаадын этгээд бол тендерийн баталгааны дагуу хүргүүлэх шаардлагыг баталгаа гаргагчийн нэрийн өмнөөс хүлээн авах Монгол Улсад үүсгэн байгууллагдсан банк, санхүүгийн байгууллага, бусад этгээдийг заана уу.]

[Банкны эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, байгууллагын тамга, тэмдэг]

Маягт 4 Тендерийн баталгаа (Засгийн газрын бондын болон Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаас)

Баталгаа хүлээн авагч: **[захиалагч байгууллагын нэр, хаягийг бичих]**

Огноо: **[баталгаа гаргасан огноог бичих]**

Дугаар: **[тендерийн баталгааны дугаар бичих]**

Баталгаа гаргагч: **[хэвлэмэл хуудсанд бичигдээгүй бол баталгаа гаргагч банкны нэр, хаягийг бичих]**

1. Баталгаа гаргагч нь **[тендерт оролцогчийн нэр]** (цаашид “тендерт оролцогч” гэх)-ийг **[тендер шалгаруулалтын нэр, дугаар]** тендер шалгаруулалтад оролцож тендер (цаашид “тендер” гэх) хүргүүлэхтэй холбогдуулан баталгаа хүлээн авагчийн өмнө нийт **[мөнгөн дүн]⁷** төгрөг буюу түүнтэй тэнцэх гадаад валютын төлбөрийн үүрэг хүлээх баталгааг нийт **[мөнгөн дүн]** төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий **[Засгийн газрын бонд эсхүл үнэт цаасны нэр болон холбогдох бусад мэдээллийг бичих]** (цаашид “Үнэт цаас” гэх)-г⁸ үндэслэн гаргаж байна.
2. Энэхүү баталгааны дагуу Үнэт цаасыг шилжүүлэх үүрэг нь дор дурдсан нөхцөлд үүснэ.
Үүнд:
 - 2.1.Тендер нээсний дараа, тендерийн хүчинтэй байх хугацаа (сунгасан хугацааг оролцуулан цаашид “Тендер хүчинтэй байх хугацаа” гэх) дуусахаас өмнө тендерт оролцогч тухайн тендерээс бүхэлд нь эсхүл хэсэгчлэн татгалзсаныг бичгээр мэдэгдсэн;
 - 2.2.Тендерт оролцогч гэрээ байгуулах эрх авсан үед тендерийн баримт бичигт заасны дагуу:
 - 2.2.1.гэрээг баталгаажуулж ирүүлээгүй;
 - 2.2.2.гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй;
 - 2.2.3.тендерийн үнийн алдааны залруулгыг хүлээн зөвшөөрөөгүй, эсхүл хүлээн зөвшөөрсөн эсэх тухай хариуг бичгээр ирүүлээгүй.
 - 2.3.Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тендерт оролцогчийн гаргасан гомдлыг бүхэлд нь үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн.
3. Дээр тодорхойлсон аль нэг нөхцөл үүссэнийг дурдаж Үнэт цаасыг шилжүүлэх тухай захиалагчийн анхны шаардлагыг хүлээн авсан даруйд баталгаа гаргагч Үнэт цаасыг Монгол Улсын Сангийн яамны нэр дээр шилжүүлнэ. Баталгаа гаргагчаас шилжүүлэх Үнэт цаасны нэрлэсэн үнийн дүн нь 1-д заасан мөнгөн дүнгээс хэтрэхгүй ба 2.3-т заасан нөхцөл үүссэн тохиолдолд 20 сая хүртэл төгрөг эсхүл түүнтэй тэнцэх гадаад валютаас хэтрэхгүй байна.
4. Энэхүү баталгаа Тендер хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байна. Баталгаа гаргагч энэ хугацаанаас өмнө гэрээ байгуулсан тухай мэдэгдлийг хүлээн авсан тохиолдолд баталгааг хугацаанаас өмнө хүчингүй болгож болно.
5. Энэхүү баталгааны дагуу гаргах аливаа шаардлагыг баталгааны хүчинтэй хугацаанд багтааж баталгаа гаргагчид мэдэгдэнэ.
6. Энэхүү баталгааг дээр дурдсанаас бусад үндэслэлээр хүчингүй болгосонтой холбоотой хариуцлагыг баталгаа гаргагч хүлээнэ.

⁷ Энэ дүн нь ТШЗ-ны 23.1-д заасантай ижил байна.

⁸ Засгийн газрын бонд болон үнэт цаасны эргэн төлөгдөх хугацаа нь тендер нээх өдрөөс хойш 3-аас доошгүй сарын дараа байна.

[Баталгаа гаргагч нь гадаадын этгээд бол тендерийн баталгааны дагуу хүргүүлэх шаардлагыг баталгаа гаргагчийн нэрийн өмнөөс хүлээн авах Монгол Улсад үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдийг заана уу.]

[Баталгаа гаргагчийн эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, байгууллагын тамга, тэмдэг]

Маягт 5 Ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээний мэдээлэл

| Гэрээний нэр | Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас | Төсөвт өртөг | Хугацаа /эхэлсэн, дууссан/ |
|--------------|--|-----------------|-------------------------------|
| | | | |
| | | | |
| | | | |
| | | | |

Маягт 6 Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

| Гэрээний нэр | Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас | Төсөвт өртөг | Гэрээ эхэлсэн хугацаа | Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр | Дуусах хугацаа |
|--------------|--|-----------------|-----------------------------|---|-------------------|
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |
| | | | | | |

Маягт 7 Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Тендерт оролцогчийн нэр: [түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].

| | |
|----|--|
| 1. | Захиалагчийн нэр |
| 2. | Гэрээний нэр |
| 3. | Гэрээний дугаар |
| 4. | Гэрээ байгуулсан огноо |
| 5. | Гэрээ дуусгавар болсон огноо |
| 6. | Гэрээний дүн |
| 7. | Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч |
| 8. | Хавсралт - Гэрээний хуулбар - Гэрээ дүгнэсэн акт / бараа хүлээлцсэн акт / захиалагчийн тодорхойлолт |

**VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ
ГАРЧИГ**

| | |
|---|---|
| ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ | 1 |
| НЭГ. ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР | 1 |
| Тодорхойлолт | 1 |
| Гэрээний тайлбар | 2 |
| ХОЁР. НИЙЛҮҮЛЭГЧ | 2 |
| Бараа нийлүүлэх | 2 |
| Бараа нийлүүлэх газар | 2 |
| Бараа нийлүүлэх хугацаа, түүнийг сунгах | 2 |
| Барааг хүлээлгэн өгөх | 3 |
| Барааны гарал үүслийн улс | 3 |
| Баглаа боодол | 3 |
| Худалдааны нөхцөл | 3 |
| Гүйцэтгэлийн баталгаа | 3 |
| ГУРАВ. ЗАХИАЛАГЧ | 4 |
| Барааг хүлээн авах | 4 |
| Шалгалт, туршилт | 4 |
| Гэрээний үнэ | 4 |
| Төлбөр төлөх | 4 |
| ДӨРӨВ. ЭРСДЭЛ БА ХАРИУЦЛАГА | 4 |
| Захиалагчийн хүлээх эрсдэл | 4 |
| Даатгал | 5 |
| Доголдол | 5 |
| Чанарын баталгаа | 5 |
| Алданги | 5 |
| Оюуны өмчийн эрх зөрчих | 6 |
| Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал | 6 |
| Үүрэг гүйцэтгүүлэх нэмэлт хугацаа | 6 |
| ТАВ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ | 6 |
| Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах үндэслэл | 6 |
| Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэл | 6 |
| ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ | 7 |
| Төлөөлөгч | 7 |
| Туслан гүйцэтгэгч | 7 |
| Нууцлал | 7 |
| Мэдэгдэл | 7 |
| Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах | 7 |
| Маргаан шийдвэрлэх | 8 |
| ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ | 8 |
| ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ | 9 |

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

НЭГ. ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

Тодорхойлолт

- 1.1. Гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл нь дор дурдсан утгыг агуулна:
 - 1.1.1. “Бараа” гэж Нийлүүлэгчээс Захиалагчид нийлүүлэхээр Тендерт ирүүлсэн хөрөнгийг;
 - 1.1.2. “Дагалдах үйлчилгээ” гэж бараа нийлүүлэхтэй холбоотой угсралт, суурилуулалт, сургалт, засвар үйлчилгээ болон Нийлүүлэгчийн үзүүлэх бусад үйлчилгээг;
 - 1.1.3. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
 - 1.1.4. “Нийлүүлэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
 - 1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Нийлүүлэгчийг хамтад нэрлэснийг;
 - 1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;
 - 1.1.7. “Бараа нийлүүлэх нөхцөл” гэж Захиалагчийн техникийн тодорхойлолтод нийцүүлж Тендерт тусгасан бараа бэлтгэх, нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг ойлгоно. Тендерт тусгайлан заагаагүй бараа нийлүүлэх нөхцөлийг Техникийн тодорхойлолтод тусгаснаар ойлгоно. Хуулийн 30.2, 34.2-т зааснаар хэлэлцээ хийсэн тохиролцоо нь Гэрээнд тусгагдсан бол Бараа нийлүүлэх нөхцөлийн нэг хэсэг болно.
 - 1.1.8. “Бараа нийлүүлэх газар” гэж барааг хүлээлгэн өгөх болон дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг;
 - 1.1.9. “Доголдол” гэж нийлүүлсэн бараа, дагалдах үйлчилгээний барааны шинж байдал, чанар тоо хэмжээ нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерээс зөрүүтэй байхыг;
 - 1.1.10. “Баталгаат хугацаа” гэж нийлүүлсэн барааг зориулалтын дагуу ердийн байдлаар ашиглах явцад бараанд илэрсэн доголдлыг нийлүүлэгч хариуцах хугацааг;
 - 1.1.11. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж гэрээгээр баталгаат хугацаа тогтоогоогүй бол Захиалагчаас доголдолтой холбогдуулж Нийлүүлэгчид шаардлага гаргах хугацааг;
 - 1.1.12. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Нийлүүлэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;
 - 1.1.13. “Нийлүүлэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Нийлүүлэгчээс томилогдсон этгээдийг;
 - 1.1.14. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал” гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах

| | | |
|--|------|---|
| | | боловижгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио тогтоосон нөхцөл байдал бий болохыг сийлгоно. |
| Гэрээний тайлбар | 1.2. | Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална: 1.2.1. Ганц тоог илэрхийлсэн үг нь олон тоог, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоог хамааруулж болно. 1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй. 1.2.3. Зүйл, заалт, үг, өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томъёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад үндэслэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана. 1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална. 1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална. |
| | | ХОЁР. НИЙЛҮҮЛЭГЧ |
| Бараа нийлүүлэх | 2.1. | Нийлүүлэгч нь гэрээнд заасан бараа нийлүүлэх нөхцөл, нийлүүлэлтийн хуваарь, ГТН-д заасан хугацааг баримтлан Бараа нийлүүлэх, Дагалдах үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй. |
| | 2.2. | Нийлүүлэгч гэрээний дагуу Дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай ажилтан, тоног төхөөрөмж зэргийг Тендерт санал болгосноор оролцуулах ба гүйцэтгэлийн явцад эдгээрт өөрчлөлт орох зайлшгүй шаардлагатай нөхцөл үүссэн бол Захиалагчаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авна. |
| | 2.3. | ГЕН-ийн 2.2-т заасны дагуу өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн шаардсан техникийн чадавх, туршлагын шаардлагыг хангасан байна. |
| | 2.4. | Нийлүүлэгч нь Барааг нийлүүлэхэд зайлшгүй шаардлагатай баримт бичиг, бусад зүйлийг гаргуулахыг хүссэн тохиолдолд Захиалагч ердийн боломжит хугацаанд гаргаж өгнө. |
| Бараа нийлүүлэх газар | 2.5. | Бараа нийлүүлэх болон Дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг ГТН-д заана. |
| Бараа нийлүүлэх хугацаа, түүнийг сунгах | 2.6. | Бараа нийлүүлэх хугацааг нийлүүлэлтийн хуваарийг үндэслэн ГТН-д заана. |
| | 2.7. | Нийлүүлэгч дараах нөхцөл бий болсон тохиолдолд бараа нийлүүлэлтийн хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно: 2.7.1. Захиалагч ГЕН-ийн 2.4-д заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй; 2.7.2. Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон. |

- | | |
|----------------------------------|---|
| Барааг хүлээлгэн өгөх | 2.8. Захиалагч ГЕН-ийн 2.7-д заасан нөхцөлийн аль нэг нь бүрдсэн гэж үзвэл Нийлүүлэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно. 2.9. ГЕН-ийн 2.7.2-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Нийлүүлэгч нотлох үүрэгтэй. 2.10. Нийлүүлэгч нь Барааг ГТН-д заасан нөхцөлөөр хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг бүрэн үзүүлж, баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ. 2.11. Нийлүүлэгч нь барааг хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг үзүүлснээр Захиалагчид барааны өмчлөх эрх шилжинэ. |
| Барааны гарал үүслийн улс | 2.12. Гэрээний дагуу нийлүүлэх Бараа нь Тендерт заасан улсын гарал үүсэлтэй байна. 2.13. Нийлүүлэгчийн Тендерийг шалгаруулахад түүнд давуу эрх олгосон бол үнэлгээний явцад үнийг нь хийсвэрээр бууруулж тооцсон аливаа бараа нь заавал Монгол Улсын гарал үүсэлтэй бараа байна. |
| Баглаа боодол | 2.14. Нийлүүлэгч барааг ГЕН-ийн 2.5-д заасан газар хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудах, дутах зэрэг доголдлоос урьдчилан сэргийлэх сав, баглаа боодлыг ГТН-д заасны дагуу хангана. 2.15. Сав, баглаа боодол, түүний хаягдал нь хүрээлэн буй орчинд учруулах сөрөг нөлөөллийг хамгийн бага байхаар сонгоно. Сав, баглаа боодолд хууль тогтоомжоор хориглосон материал ашиглахыг хориглоно. 2.16. Нийлүүлэгч баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичгийг бэлтгэхдээ ГТН-д заасан шаардлага болон Захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг мөрднө. |
| Худалдааны нөхцөл | 2.17. Гэрээнд Худалдааны нөхцөл (Incoterms)-ийг хэрэглэх бол тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ-ны 20.6-д заасан нөхцөлийг ГТН-д тусгана. 2.18. ГТН-д заагаагүй бол Incoterms 2020 Delivery Duty Paid /DDP/ нөхцөлөөр бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ. |
| Гүйцэтгэлийн баталгаа | 2.19. Гүйцэтгэлийн баталгаа гаргуулахаар ТӨХ-д заасан бол Нийлүүлэгч нь гэрээний үнийн 5 хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. 2.20. Захиалагч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг Нийлүүлэгчийн Гүйцэтгэлийн баталгаагаар үл маргах журмаар хангулна: 2.20.1. Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ аливаа шалтгааны улмаас гүйцэтгээгүй; 2.20.2. Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй; 2.20.3. Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон. 2.21. Захиалагч гүйцэтгэлийн баталгаагаар үүргийн гүйцэтгэлийг хангулсан нь Нийлүүлэгчээс алданги, хохирол шаардах эрхийг хязгаарлахгүй. 2.22. ГЕН-ийн 2.8-д заасны дагуу хугацаа сунгагдсан тохиолдолд Нийлүүлэгч гүйцэтгэлийн баталгааг мөн хугацаагаар сунгуулна. |

- 2.23. Чанарын баталгаа шаардсан тохиолдолд ГЕН-ийн 4.11-д заасан Чанарын баталгаа гаргасан тохиолдолд Гүйцэтгэлийг баталгааг чөлөөлнө.

ГУРАВ. ЗАХИАЛАГЧ

Барааг хүлээн авах

- 1.1. Захиалагч нь барааг хүлээн авч, хүлээлцсэн баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.

Шалгалт, туршилт

- 1.2. Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээ, үйлдвэрлэлийн үйл явц Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт нийцэж буй эсэхийг хянах зорилгоор Захиалагч шалгалт, туршилт явуулах эрхтэй. Шалгалт, туршилт хийх хугацаа, журмын талаар Захиалагч нь Нийлүүлэгчид бичгээр урьдчилан мэдэгдэнэ. 1.3. Шалгалт, туршилтын явцыг тэмдэглэл үйлдэн талууд баталгаажуулах бөгөөд бараа, дагалдах үйлчилгээ доголдолтой тохиолдолд Захиалагч доголдлыг арилгуулахаар Нийлүүлэгчид мэдэгдэл хүргүүлнэ. 1.4. ГЕН-ийн 3.3-т заасан мэдэгдлийн дагуу Нийлүүлэгч барааны доголдлыг арилгах арга хэмжээ авна. 1.5. Барааг хүлээн авахаас өмнө Захиалагч шалгасан, туршсан байх нь хүлээн авах үед түүнийг дахин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд барааг хүлээн авахаас татгалзах, доголдолтой холбогдуулж шаардлага гаргах Захиалагчийн эрхийг хязгаарлахгүй. 1.6. Шалгалт, туршилт хийхтэй холбоотой аливаа зардлыг Нийлүүлэгч хариуцна.

Гэрээний үнэ

- 1.7. Гэрээний үнийг Гэрээ баталгаажуулах маягтад заана. 1.8. Гэрээний үнэд хуулийн 40.4-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д заана.

Төлбөр төлөх

- 1.9. Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг Нийлүүлэгчид төлнө. 1.10. Нийлүүлэгчийн хүсэлтээр Захиалагч Бараа нийлүүлэх хугацааг ГЕН-ийн 2.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ. 1.11. Захиалагч нь гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон бусад холбогдо баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно. 1.12. Захиалагч урьдчилгаа төлбөр төлөхгүй. 1.13. ГЕН-ийн 3.8-д заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална. 1.14. Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна. 1.15. Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Нийлүүлэгчид төлөх төлбөрөөс сутгана.

ДӨРӨВ. ЭРСДЭЛ БА ХАРИУЦЛАГА

**Захиалагчийн хүлээх
эрсдэл**

- 4.1. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:
- 4.1.1. Барааг захиалагчид шилжүүлснээс хойш бараа нь ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар гэмтсэн, устсан;
- 4.1.2. Нийлүүлэгч Барааг гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөх тодорхой үйлдэл хийсэн боловч Захиалагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүлээн аваагүй (доголдолтой бараанд хамаарахгүй) байх

| | | |
|-------------------------|-------|--|
| | | хугацаанд ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар Бараа гэмтсэн, устсан. |
| Даатгал | 4.2. | Нийлүүлэгч нь барааг үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, хүлээлгэн өгөх үед гарч болох эрсдэлээс хамгаалж ГТН-д заасны дагуу даатгуулж, даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг Захиалагчид ирүүлнэ. Даатгалын хураамжийг Нийлүүлэгч хариуцна. |
| Доголдол | 4.3. | Захиалагч бараа, дагалдах үйлчилгээг шалгаж, илэрсэн зөрчил, доголдлын талаар Нийлүүлэгчид мэдэгдэнэ. |
| | 4.4. | Захиалагч зөрчил, доголдлыг илрүүлэх зорилгоор барааны далд хэсгийг нээх, шалгалт, туршилт хийх эрхтэй. |
| | 4.5. | Захиалагч ГТН-д заасан баталгаат хугацаа эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг нийлүүлэгчид өгнө. |
| | 4.6. | Доголдол арилгах мэдэгдэл өгсөн тухай бүр Нийлүүлэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана. |
| | 4.7. | Нийлүүлэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгана. |
| | 4.8. | Захиалагчийн гаргасан зардлыг Нийлүүлэгч Захиалагчид үл маргах журмаар төлнө. |
| | 4.9. | Захиалагч нь ГЕН-ийн 4.7-д заасан зардлыг Чанарын баталгаанаас суутгаж болох бөгөөд Чанарын баталгаа хүрэлцээгүй тохиолдолд илүү гарсан зардлыг Нийлүүлэгч нь Захиалагчид үл маргах журмаар төлнө. |
| Чанарын баталгаа | 4.10. | Бараа, дагалдах үйлчилгээний баталгаат хугацааг ГТН-д заана. |
| | 4.11. | ГТН-д заасан бол чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно. |
| | 4.12. | Нийлүүлэгч Чанарын баталгааг хуулийн 43.7-д заасны дагуу баталгаажуулж болно. |
| | 4.13. | ГЕН-ийн 4.12-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно. |
| | 4.14. | Баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Бараанд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө. |
| | 4.15. | ГЕН-ийн 4.7-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Нийлүүлэгчид олгоно. |
| | 4.16. | ГЕН-ийн 4.7-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ. |
| Алданги | 4.17. | Нийлүүлэгч нь барааг хуваарийн дагуу буюу гэрээнд заасан хугацаанд нийлүүлэгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө. |
| | 4.18. | Захиалагч нь төлбөр төлөх үргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Нийлүүлэгчид төлнө. |

- | | |
|---|---|
| <p>Оюуны өмчийн эрх зөрчих</p> <p>Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал</p> <p>Үүрэг гүйцэтгүүлэх нэмэлт хугацаа</p> <p>Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах үндэслэл</p> <p>Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэл</p> | <p>4.19. Барааг өмчлөх, эзэмших, ашиглах явцад гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.</p> <p>4.20. Барааг гэрээнд заасан хугацаанд нийлуулэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Нийлүүлэгч нь энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 6.10-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.</p> <p>4.21. Нийлүүлэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.</p> <p>4.22. Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцэж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.</p> <p>4.23. Гэрээг хэрэгжүүлэх Захиалагчийн зааварчилгаа, Нийлүүлэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Нийлүүлэгч ГЕН-ийн 2.7-д заасан хүсэлт гаргаж болно.</p> <p>4.24. Гэрээний нэг тал нь үүргийн зөрчил гаргасан тохиолдолд нөгөө талд үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоож, мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.</p> <p>4.25. Иргэний хуулийн 226 дугаар зүйлд заасан үндэслэл бий болсон тохиолдолд эсхүл Нийлүүлэгч ГЕН-ийн 2.13-т заасныг зөрчсөн бол нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.</p> |
|---|---|

ТАВ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ

- 5.1. Захиалагч дараах үндэслэлийн аль нэг нь хангагдсан тохиолдолд гэрээнээс татгалзах эсхүл гэрээг цуцлах эрхтэй:
 - 5.1.1. Нийлүүлэгч гэрээнд заасан хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоосон боловч нэмэлт хугацаанд гүйцэтгээгүй;
 - 5.1.2. Бараа нийлүүлэх хугацаанд Нийлүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дуусч сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон;
 - 5.1.3. Нийлүүлэгч ГЕН-ийн 6.5-д заасан үүргээ зөрчсөн нь тогтоогдсон.
- 5.2. Нийлүүлэгч тендерт оролцох буюу бараа нийлүүлэх явцдаа авилгал, залилан мэхлэх гэмт хэрэг үйлдсэн нь шүүх болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон.
- 5.3. Захиалагч нь төлбөр хийх хугацаа хэтэрсэн тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш тогтоосон хугацаанд төлбөрийг төлөөгүй тохиолдолд Нийлүүлэгч гэрээг цуцалж болно.
- 5.4. Нийлүүлэгч ямар ч тохиолдолд гэрээнээс татгалзах эрхийг хэрэгжүүлэхгүй.
- 5.5. Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэлд гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах болсон үндэслэл, цаашид гэрээг дуусгавар болсонтой холбоотой авах арга хэмжээний тухай тусгасан байна.

ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ

- | | |
|---|---|
| Төлөөлөгч | 6.1. Талууд өөрийн төлөөлөгчийг томилж, томилсон төлөөлөгчийн мэдээллийг гэрээ баталгаажуулах маягтад заана. 6.2. Төлөөлөгчийн мэдээлэлд түүний эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаяг тэмдэглэгдсэн байна. 6.3. Гэрээ хэрэгжүүлэх явцад төлөөлөгч солигдсон бол Төлөөлөгч солигдсон тухай болон түүний мэдээллийг агуулсан мэдэгдлийг нөгөө талд бичгээр хүргүүлнэ. 6.4. Төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусад шилжүүлэхийг хориглоно. 6.5. Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж байгаа тохиолдолд Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт зааснаас илүү хувийг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй. 6.6. Туслан гүйцэтгэгчийн аливаа зөрчлийг (хугацаа хэтрүүлэх, ажлын доголдол гэх мэт) Нийлүүлэгч хариуцах бөгөөд Туслан гүйцэтгэгч өөрчлөгдсөн тохиолдолд ГЕН-ийн 2.3-д заасан журмыг баримтална. |
| Туслан гүйцэтгэгч | 6.7. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй. 6.8. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийг хамт өгнө. 6.9. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ. |
| Нууцлал | 6.10. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн тухай мэдэгдлийг ГЕН-ийн 6.9 -д зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг баталгаажуулж бичгээр хүргүүлнэ. 6.11. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан Төлөөлөгчийн хаягаар илгээнэ. 6.12. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно: 6.12.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр, төлбөр төлсөн баримтыг үндэслэн; 6.12.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн. |
| Мэдэгдэл | 6.13. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ. 6.14. ГЕН-ийн 6.13-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна. 6.15. Дараах тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулна: 6.15.1. ГЕН-ийн 2.8-т заасны дагуу хугацаа сунгагдсан; 6.15.2. үнийн тохироулга хийсэн. |
| Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах | |

- Маргаан шийдвэрлэх**
- 6.16. Гэрээний нэмэлт, өөрчлөлтөд талуудын эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.
 - 6.17. ГЕН-ийн 6.15-д зааснаас бусад тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахгүй.
 - 6.18. Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг талууд зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
 - 6.19. Талууд зөвшилцөн, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

| | |
|------------------|---|
| ГЕН 2.5. | Бараа нийлүүлэх газар: Дорноговь аймаг Замын-Үүд сүм 4 дүгээр цэцэрлэг |
| ГЕН 2.6. | Бараа нийлүүлэх хугацаа: Гэрээ байгуулснаас хойш |
| ГЕН 2.10. | Бараа хүлээлгэн өгөх нөхцөл: Монгол улсад мөрдөгдөж байгаа чанар стандартыг мөрдөх Бараанд холбогдох баримт бичиг: Барааны шинжилгээний бичиг |
| ГЕН 2.14. | Баглаа, боодол: Хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодлын стандарт шаардлагыг хангана. |
| ГЕН 2.17. | Худалдааны нөхцөл: |
| ГЕН 3.8. | Үнийн тохироулга хийх аргачлал: |
| ГЕН 3.9. | Төлбөр төлөх хугацаа: Сар бүр гүйцэтгэлээр |
| ГЕН 4.2. | Даатгал: |
| ГЕН 4.10. | Баталгаат хугацаа: |
| ГЕН 4.11 | Чанарын баталгаа: Чанарын баталгаа шаардах эсэх: шаардахгүй Чанарын баталгааны дүн: 0 |
| ГЕН 4.17. | Нийлүүлэгчийн төлөх алданги : Алданги тооцох эсэх: “Тийм” Алдангийн хувь: хоног тутамд гэрээний үнийн дунгийн 0.1 хүртэл хувиар |
| ГЕН 4.18. | Захиалагчийн төлөх алданги : |

ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

[Тендер шалгаруулалтын нэрийг бичих] гэрээ.
Дугаар № [Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэрийг бичих] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [нийлүүлэгчийн нэрийг бичих] (цаашид “нийлүүлэгч” гэх) нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Нийлүүлэгчийн хооронд бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Бараа” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу нийлүүлэх Барааны үнэ нь [гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дүнг тоогоор болон үсгээр бичих] төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг Нийлүүлэгч [Нийлүүлэгчийн нэрийг бичих]-ийн харилцах [Банкны нэрийг бичих] банкны [дансны дугаар бичих] дугаар дансанд шилжүүлнэ.
3. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
 - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 - 3.2. Нийлүүлэгч тендер илгээсэн маягт;
 - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
 - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
 - 3.5. Гүйцэтгэлийн баталгаа;
 - 3.6. Техникийн тодорхойлолт;
 - 3.7. Бараа нийлүүлэлтийн хуваарь.
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
 - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:
Гар утас:
Цахим шуудан:
 - 4.2. Нийлүүлэгчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:
Гар утас:
Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____